



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 124,920,000.00 (нэг зуун хорин дөрвөн сая есөн зуун хорин мянга) төгрөгийн балансын үнэ, 56,214,000.00 (тавин зургаан мянга хоёр зуун арван дөрвөн мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга Б.Гүрсоронзон, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Чагнаадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл удирдлага зохицуулалтын цахим систем"-д бүртгэх

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД

13200051
8-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 04 дугаар сарын 03 ны өдрийн
17.5 дугаар тогтоолын хавсралт

"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ "ДАРХАНЫ
ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

д/д	Автомашины нэр, улсын дугаар	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Суудлын автомашин, Ланд- крийзер 76, 01-04 СЭН, арлын дугаар: JTEEU71J40F001963	2020	124,920,000.00	56,214,000.00	68,706,000.00
Нийт дүн			124,920,000.00 (нэг зуун хорин дөрвөн сая есөн зуун хорин мянга)	56,214,000.00 (тавин зургаан сая хоёр зуун арван дөрвөн мянга)	68,706,000.00 (жаран найман сая долоон зуун зургаан мянга)